



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 11 сарын 03 -ны өдөр

Дугаар А/93

Эрдэнэт

Гэрийн эргэлтэд шилжүүлэх тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, 2022 оны "Журам, заавар батлах тухай" А/373 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Улирлын томуу, томуугийн цартахлын хүндрэлийн үнэлгээ (УТТЦХҮ)-гээр томуу төст өвчний тархалт "Алаг цоог дэгдэлт"-н түвшинд хүрсэн тул сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг 2022 оны 11 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн 0-5 нас, жирэмсэн, 65-наас дээш насны иргэд, архаг хууч өвчтэй эрсдэлт бүлгийн хүн амд үзүүлэх тусламж үйлчилгээг гэрийн эргэлтэд шилжүүлэхийг сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт даалгасугай.

2. Гэрийн эргэлтийн мэдээ тайлан авах маягыг нэгдүгээр, шаардлагатай шатахууны зардлын тооцоо, хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус, тус баталсугай.

3. Томуу, томуу төст өвчний тархалтын үе шатад тохирсон бэлэн байдал, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулж томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг эрчимжүүлэн ажиллахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

4. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд шаардлагатай шатахууны зардлыг хуваарийн дагуу олгохыг салбарын санхүү бүртгэл нягтлан бодох бүртгэл хариуцсан ажилтан /Н.Чулуун-Эрдэнэ/-д даалгасугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудит хариуцсан мэргэжилтэн /Г.Энхжаргал/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮХЭЭ

...сарын 03.-ны өдрийн 1/23 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

ШААРДЛАГАТАЙ ШАТАХУУНЫ ЗАРДЛЫН ХУВААРЬ

№	ӨЭМТ-ИЙН НЭР	ЗАРДАЛ
1	Анхны-Оч	1.000.000 төг
2	Мэндцэцэн	1.000.000 төг
3	Нийцэл	1.000.000 төг
4	Мөнхийн Гэгээ	1.000.000 төг
5	Учралтбаяр	1.000.000 төг
6	Энхжихмандариваа	1.000.000 төг
7	Мөнхсүндрэл	1.000.000 төг
8	Үйлсбадрах	1.000.000 төг
9	Жаргалант	1.000.000 төг